



**НИЙСЛЭЛИЙН  
СПОРТЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалт, Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/518 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг угтаж байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Үүнд:

Ахлагч	С.Саранцэцэг
Нарийн бичиг	Э.Мөнх-Эрдэнэ
Гишүүд	А.Болдмаа
	Н.Өлзийжаргал
	Л.Төгөлдөр
	Г.Бямбасайхан
	Б.Солонго
	Х.Дэлгэр

2. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын тайлан, явцын мэдээ, урьдчилсан үзлэгийг 2019 оны 08 дугаар сарын 15-ны дотор байгууллагатай зохион байгуулж тайлан мэдээг танилцуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Улсын үзлэгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын тайлан явцын мэдээ, урьдчилсан үзлэгийг шаардлагын дагуу, цаг хугацаанд нь гаргаж танилцуулахад хяналт тавьж ажиллахыг хэсгийн ахлагч /С.Саранцэцэг/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБОЛД